



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/108

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар Ховд их сургуулийн Лицей ахлах сургуулийн барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Ш.Нохойжав - Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Т.Бат-Эрдэнэ -Ховд Их сургуулийн эдийн засагч

Д.Нямжаргал - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ж.Ганболд - Хувийн хэвшлийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Ж.Батлхагва -Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Ж.Батлхагва/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД